



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2013 оны тайлан сонссонтой холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны тайлан сонссонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/нийгмийн даатгалын багц хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах замаар эрх зүйн орчинг шинэчлэх асуудлыг яаралтай боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх;


3/нийгмийн даатгалын салбарын орон тоо, бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах;

4/нийгмийн даатгалын салбарын мэдээллийн техник, технологи, программ хангамжийг иж бүрэн шинэчлэх ажлыг зохион байгуулах;

5/Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж ирүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Д.Батцогт/-нд даалгасугай.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦОГТ